



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Өрнөх эрүүл жаргал ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/220/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудитын газрын ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11315558 Цахим хаяг: Altantsetsegya@audit.gov.mn Номч финанс аудит ХХК-ийн захирал: Ц.Эрдэнэбилэг Утас: 88009020 Цахим хаяг: nomchfinanceaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025 - 12 - 13 № 817
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН ӨРНӨХ ЭРҮҮЛ ЖАРГАЛ
ӨЭМТ-ИЙН ДАРГА Ж. ОЮУНАА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Өрнөх эрүүл жаргал ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурьдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 15.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан, гүйцэтгэлээр санхүүжилтээ авч ажиллаж байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Өрнөх эрүүл жаргал ӨЭМТ нь 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 659.3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, Эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 108 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны А/99 дугаар тушаалаар 93.4 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.8 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	31,308,370.76	113,729,092.47
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,777,581.47	9,487,320.19
Дансны авлага	7,126,191.04	7,985,265.50
Бусад авлага	9,954,148.25	38,618,963.78
Бараа материал	7,450,450.00	57,637,543.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	228,210,710.84	239,348,131.29
Үндсэн хөрөнгө	228,210,710.84	239,348,131.29
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	259,519,081.60	353,077,223.76
Өр төлбөр		
Дансны өглөг	193,264,540.71	189,644,540.71
Татварын өр	20,799,517.11	59,059,642.96
НДШ-ийн өглөг	53,976,986.41	75,487,175.89
Урьдчилж орсон орлого	-	859,074.46
Цалингийн өглөг	-	568,266.00
Бусад богино хугацаат өр төлбөр	-	35,989,940.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	268,041,044.23	361,608,640.02
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	268,041,044.23	361,608,640.02
Эздийн өмч		
Өмч: - хувийн	200,000.00	200,000.00
Хуримтлагдсан ашиг	(8,721,962.63)	(8,731,416.26)
Эзэмшигчдийн өмчийн дүн	(8,521,962.63)	(8,531,416.26)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	259,519,081.60	353,077,223.76

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант үе
Санхүүжилтын орлого	423,588,665.07	659,277,193.11
Бусад орлого	33,336,200.00	480,000.00
Үйл ажиллагааны орлого	456,924,865.07	659,757,193.11
Ерөнхий ба удирдлагын зардал	452,404,840.67	659,766,646.74
Үйл ажиллагааны зарлага	452,404,840.67	659,766,646.74
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,520,024.40	(9,453.63)
Татварын дараах ашиг (алдагдал)	4,520,024.40	(9,453.63)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,520,024.40	(9,453.63)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	200,000.00	-	(13,241,987.05)	(13,041,987.05)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	4,520,024.42	4,520,024.42
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	200,000.00	-	(8,721,962.63)	(8,521,962.63)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(9,453.63)	(9,453.63)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	200,000.00	-	(8,731,416.26)	(8,531,416.26)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант үе
Мөнгөн орлогын дүн(+)	416,462,474.05	659,757,193.11
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	416,462,474.05	659,757,193.11
Мөнгөн зарлагын дүн(-)	384,384,642.58	613,219,554.39
Ажиллагчдад төлсөн	252,424,690.00	476,129,856.63
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	26,182,646.33	73,416,899.59
Бараа материал худалдан авахад төлсөн	13,145,852.00	49,105,388.17
Ашиглалтын зардалд төлсөн	5,423,620.12	6,090,968.00
Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,804,534.00	4,759,402.00
Татварын байгууллагад төлсөн	8,966,955.89	2,000,000.00
Бусал мөнгөн зарлага	75,436,344.24	1,717,040.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	32,077,831.47	46,537,638.72
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн(+)	-	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн(-)	-	43,827,900.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	31,800,250.00	43,827,900.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(31,800,250.00)	(43,827,900.00)
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,500,000.00	-
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,500,000.00	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,466,356.30	2,709,738.72
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	311,225.17	6,777,581.47
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,777,581.47	9,487,320.19

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,159.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 15,159.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн байна.	1	2,399.9	-	-	1	2,399.9	-	-	-	-
2	Жолоочийн замын хуудасгүй шатахууны зардлыг бүртгэлд тусгасан.	1	4,759.4	-	-	1	4,759.4	-	-	-	-
3	Үйл ажиллагааны чиглэл зөрчиж ажилчдад зээл олгосон байна.	1	8,000.0	-	-	1	8,000.0	-	-	-	-
Дүн		3	15,159.3	-	-	3	15,159.3	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн аудиттай холбоотой 274,634.6 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр арван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх 2 дугаар улирлын 274,634.6 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	274,634.6	1	274,634.6	-	-
Дүн		1	274,634.6	1	274,634.6	-	-